



АУДИТЫН КОД: САГ-2018/124/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Б.Уянга

Утас: 260512 Цахим хаяг: uyangab@audit.gov.mn

“Баян ташаагийн эх Аудит” ХХК

Захирал: Т.Хоролсүрэн Утас:99116028,99062255

Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Байршил: Баянгол дүүрэг,4-р хороо, 2-р хороолол, П.Жамсрайн гудамж, 24/1 байр, 6,7 тоотууд

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	4
2.3	Байгууллагын хууль, эрх зүйн орчин	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	5
2.5	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	5
2.6	Дотоод хяналт	6
2.7	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.8	Шилэн дансны мэдээлэл	6
2.9	Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар.....	6
2.10	Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	7
2.10.1	Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэгдүүлсэн хөрөнгийн өөрчлөлт хийгээгүй	7
2.10.2	Бодлогын баримт бичиг нь санхүүгийн програмын дансны заавар, кодтой нийцэхгүй байх.....	7
2.11	Залруулагдаагүй алдааны талаарх тайлбар	7
2.12	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.13	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
2.14	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
2.15	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
2.16	Материаллаг байдал	8
2.17	Санал дүгнэлтийн үндэслэл	8
3	Менежментийн захидал	9
3.1	Асуудал 1: Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар.....	10
3.2	Асуудал 2: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ХАРЬЯА УДИРДЛАГЫН
АКАДЕМИЙН ЗАХИРАЛ С.ЗУЛПХАР
ТАНАА

2018.03.15 № 06/684
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


10.10.2018 Bichig_Kherig\Yawsan_Bichig\2018\0315SA 37-Doog
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ 018577

Үүрэг, хариуцлага

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академи нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Удирдлагын академийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Удирдлагын академийн захирал С.Зулпхар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Удирдлагын академи нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Тухайн Санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-наас 2018 оны 3 дугаар сарын 14-ний хооронд хийхээр төлөвлөн “Баян ташаагийн эх Аудит” ХХК-ний аудитор Д.Түмэндэмбэрэл, аудитын менежер Ч.Чимгээ аудиторын туслах Г.Хишигдулам, Д.Балжирдорж нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Удирдлагын академийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 22-нд 04/13 тоот албан бичгээр “Баян ташаагийн эх Аудит” ХХК-д ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Удирдлагын академи нь Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын Академийн анхны шав тавигдсан нь 1924 оны 4 дүгээр сарын 5-нд Халхын дөрвөн аймаг, шавиас зарлан дуудаж ирүүлсэн 18-30 насны 60 залуучуудаас бүрэлдсэн “Нам, улсын Түр сургууль”-ийг байгуулснаар эхэлсэн юм.

Удирдлагын академи нь эрхэм зорилгоо “Манлайлан ажиллах төгсөгч, мэдлэг тэлэх судалгаа, хөгжилд хөтлөх зөвлөгөөг бид бүтээнэ” гэж тодорхойлсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яамтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө” гэж заасны дагуу Удирдлагын академийн захирал нь удирдаж байна.

Тус байгууллагын захиралтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай хуулиуд болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох журам, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Удирдлагын академийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.5 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд Санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлсэн.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 21 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Удирдлагын академийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2014 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй боловч энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэхгүй байна.

Удирдлагын академийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг гүйцэтгэлээ.



Удирдлагын академийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Нью Радианс ХХК-ийн Юникус санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.6 Дотоод хяналт

Бид Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Удирдлагын академийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд тус байгууллага нь гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаж байгаа гэж үзлээ.

2.7 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2017 онд Удирдлагын академи нь өөрийн орлогоор санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхээс гадна Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас засгийн газрын захиалгат сургалт, судалгааны ажлын санхүүжилт авч нийт 4,668.4 сая төгрөгийн батлагдсан төсөвтэйгээр ажилласнаас тайлант хугацаанд 5,277.1 сая төгрөгийн мөнгөн орлоготой, 4,458.0 сая төгрөгийн мөнгөн зарлагын гүйцэтгэлтэй ажилласан байна. Нийт орлогын 1,097.4 сая төгрөг буюу 20.8 хувийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын урсгал төсвийн санхүүжилтээр, 4,179.7 сая төгрөг буюу 79.8 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоор тус тус бүрдүүлсэн байна. Тайлангийн жилийн эцэст харилцах дансны үлдэгдэл 4,231.5 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг сар, улирлын хуваариар гаргаж биелэлтийг тооцож гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2.8 Шилэн дансны мэдээлэл

Төсвийн шууд захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж цахим хуудсандаа шилэн данс цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

Дараах мэдээллийг шилэн дансанд тогтмол байршуулсан.

1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт
2. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
4. Санхүүгийн тайлан
5. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт

2.9 Олж тогтоосон гол эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 26 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс тус бүрээр нийт 21 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

2.10 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР

2.10.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэгдүүлсэн хөрөнгийн өөрчлөлт хийгээгүй

Тус байгууллага нь 2015 онд өөрийн хөрөнгийн хэмжээг 302.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэгдүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг хийлгээгүй байна. Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалаар баталсан "Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Улсын бүртгэлийн гэрчилгээнд зохих өөрчлөлтийг хийх зөвлөмж өглөө.

2.10.2 Бодлогын баримт бичиг нь санхүүгийн програмын дансны заавар, кодтой нийцэхгүй байх

Тус байгууллага нь 2014 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалтай нийцэхгүй, санхүүгийн програмын дансны кодтой зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, 18 дугаар зүйлийн 18.2-д "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулж байгууллагад ашиглагдах дансны кодыг санхүүгийн програмд нэвтрүүлэн дансны кодчилолтой ижил болгон мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

2.11 ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНЫ ТАЛААРХ ТАЙЛБАР

Аудитын явцад залруулах боломжгүй алдаа зөрчил гараагүй болно.

2.12 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.13 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Удирдлагын академийн дараагийн аудитаар сургалтын төлбөрийн жишиг үнэ, тогтоолт, төвлөрүүлэлт талаар авч үзэх болно.

2.14 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

2.15 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Удирдлагын академийн 2016 оны санхүүгийн тайланд "Ньюдийл Аудит" ХХК аудит хийж урьдчилж орсон орлоготой холбоотой 1 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийг 100 хувь биелүүлсэн байна.

2.16 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцов.

Тайлант оны санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр материаллаг байдлын түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,316.8 сая төгрөгийг суурь болгон түүний 1 хувиар буюу 43.2 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж үзэхэд шинж чанар орчин нөхцлийн хувьд материаллаг шинжтэй зүйл илрээгүй.

2.17 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Зөрчилгүй санал дүгнэлт

Удирдлагын академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартд нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд санхүүгийн хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан байна.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Удирдлагын академийн санхүүгийн албаны ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 Асуудал 1: Улсын бүртгэлийн
ГЭРЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь 2015 онд өөрийн хөрөнгийн хэмжээг 302.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэгдүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг хийлгээгүй байна. Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалаар баталсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ыг мөрдөж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх

Төсвийн шууд захирагчийн хариу

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг Төсвийн шууд захирагч асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.2 Асуудал 2: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь 2014 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалтай нийцэхгүй, санхүүгийн програмын дансны кодтой зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, 18 дугаар зүйлийн 18.2-д "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй байх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулж байгууллагад ашиглагдах дансны кодыг санхүүгийн програмд нэвтрүүлэн дансны кодчилолтой ижил болгон мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 2-нд Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн шууд захирагчийн хариу

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг Төсвийн шууд захирагч асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.



4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

БАЛАНСЫН ЗҮЙЛ 2	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ 2017.01.01 4	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ 2017.12.31 5
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3,412,328,748.94	4,231,457,741.13
Кассд байгаа бэлэн мөнгө	-	-
Жижиг мөнгөн сан		
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	3,412,328,748.94	4,231,457,741.13
Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/		
АВЛАГА	975,359,219.64	955,133,365.64
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
Бусад авлага	975,359,219.64	955,133,365.64
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	-	-
Урьдчилгаа тооцоо	-	-
Урьдчилж гарсан зардал		
БАРАА МАТЕРИАЛ	52,435,914.34	72,781,056.34
Түүхий эд материал	10,855,610.00	11,204,570.00
Дуусаагүй үйлдвэрлэл		
Бэлэн бүтээгдэхүүн		
Хангамжийн материал	16,028,579.34	10,378,490.34
Мал, амьтад		
Бусад	25,551,725.00	51,197,996.00
НӨӨЦИЙН БАРАА	-	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,440,123,882.92	5,259,372,163.11
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,698,679,148.05	1,894,845,064.04
Биет хөрөнгө	1,681,268,238.02	1,888,807,860.57
Барилга байгууламж	5,741,577,332.16	5,791,034,132.16
Хуримтлагдсан элэгдэл	(4,666,409,507.04)	(4,696,152,956.40)
Авто тээврийн хэрэгсэл	43,834,120.00	86,196,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(43,834,120.00)	(37,047,388.94)
Машин тоног төхөөрөмж	553,254,433.52	597,811,115.88
Хуримтлагдсан элэгдэл	(436,968,142.25)	(454,843,705.49)
Тавилга аж ахуйн эд хогшил	402,756,688.26	476,702,535.02
Хуримтлагдсан элэгдэл	(209,399,672.06)	(174,210,104.39)
Номын фонд	161,255,048.18	169,300,278.18
Хуримтлагдсан элэгдэл		
Бусад үндсэн хөрөнгө	160,983,061.57	165,876,311.57
Хуримтлагдсан элэгдэл	(25,781,004.32)	(35,858,357.02)
Дуусаагүй барилга байгууламж		
Биет бус хөрөнгө	17,410,910.03	6,037,203.47
Программ хангамж	36,310,230.00	36,310,230.00
Хуримтлагдсан элэгдэл	(18,899,319.97)	(30,273,026.53)
Бусад	517,892,000.00	517,892,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(517,892,000.00)	(517,892,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,698,679,148.05	1,894,845,064.04
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,138,803,030.97	7,154,217,227.15
ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Өглөг	64,122,027.00	71,068,302.00
Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	-
Бусад өглөг	64,122,027.00	71,068,302.00
Урьдчилж орсон орлого	1,691,910,000.00	1,989,489,400.00
Урьдчилгаа - Төсвийн татаас		
Бусад урьдчилж орсон орлого	1,691,910,000.00	1,989,489,400.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,756,032,027.00	2,060,507,702.00

Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит


УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	-	-
Урт хугацаат зээл		
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
НИЙТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	1,756,032,027.00	2,060,507,702.00
ЭЗНИЙ ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	4,382,771,003.97	5,093,709,525.15
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,382,771,003.97	5,093,709,525.15
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,138,803,030.97	7,154,217,227.15



Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,049,653,050.00	1,161,449,920.00
Улсын төсвөөс		
Урсгал		1,097,415,000.00
Бусад төсөвт байгууллагаас		
Нийгмийн даатгалын сангаас СТСан	17,303,050.00	
Бусад тусгай зориулалтын сангаас	-	-
Тусламжийн орлого		64,034,920.00
Бараа, үйлчилгээний орлого	3,887,315,596.42	3,866,260,821.54
Өмчийн орлого		19,762,057.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	3,887,315,596.42	3,846,498,764.54
Торгууль, төлбөрийн орлого		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,936,968,646.42	5,027,710,741.54
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	2,491,826,852.82	2,691,121,502.11
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,252,279,266.99	2,429,699,956.57
Цалин	2,077,608,488.60	2,258,995,413.03
Цалингийн тусгай нэмэгдлүүд	26,996,875.00	
Гэрээт ажлын хөлс		17,515,560.00
Хоол унааны хөнгөлөлт	147,673,903.39	153,188,983.54
Нийгмийн хамгааллын шимтгэл	239,547,585.83	261,421,545.54
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	239,547,585.83	261,421,545.54
Эрүүл мэндийн даатгалын хураамж		
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	2,355,041,076.82	1,625,650,718.25
Тогтмол зардал	239,811,555.80	224,670,953.36
Гэрэл цахилгааны зардал	75,552,841.15	68,363,322.00
Түлш, халаалтын зардал	110,885,487.65	105,237,024.00
Цэвэр, бохир усны зардал	53,373,227.00	51,070,607.36
Бусад бараа үйлчилгээний зардал	2,115,229,521.02	1,400,979,764.89
Бичиг хэргийн материалын зардал	24,772,256.01	31,337,284.00
Тээвэр, шатахууны зардал	11,130,000.00	15,925,000.00
Шуудан холбооны зардал	32,525,311.41	33,317,560.21
Дотоод томилолтын зардал		4,501,650.00
Гадаад томилолтын зардал	37,122,887.00	28,399,412.00
Ном, хэвлэлийн зардал	4,612,683.00	7,013,890.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	443,605,546.00	78,248,950.00
Эрдэм шинжилгээний ажлын зардал	22,546,483.71	188,288,604.67
Жижиг эд хогшил худалдан авах зардал		5,024,140.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	9,809,069.00	14,919,977.00
Харуул, хамгаалалтын зардал	96,240,000.00	80,400,000.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	161,323,600.00	186,010,440.00
Маягт хэвлүүлэх зардал		
Урсгал засварын зардал	488,840,746.00	468,650,705.00
Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	7,061,260.00	8,891,550.00
Гадаад зочны зардал	13,011,782.00	26,403,242.00
Аудитын баталгаажуулалт, зэрэглэл тогтоох төлбөр	13,000,000.00	3,000,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдолын зардал	638,765,323.81	145,678,064.01
Тээврийн хэрэгслийн татвар	570,940.00	883,340.00
Газрын төлбөр	880,000.00	919,336.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх зардал	4,679,840.00	8,200,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,359,000.00	
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	61,979,000.00	59,949,370.00
Бүтцийн өөрчлөлтийн улмаас чөлөөлөгдсөн	2,250,000.00	5,017,250.00
Бусад хөрөнгийн		
Нөхөн олговор	15,143,798.08	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	4,846,867,929.64	4,316,772,220.36
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /бодит/		
Үндсэн хөрөнгө худалдсаны олз		



Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз /бодит/		
Хөрөнгө худалдсаны гарз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(I)+(IV)-(V)	90,100,716.78	710,938,521.18

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,160,774,482.44	-	2,131,895,804.75	4,292,670,287.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдаа				-
Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө				-
Тайлангийн үеийн үр дүн			90,100,716.78	90,100,716.78
Өмнөх оны хуримтлагдсан элэгдэл нөхөн байгуулсан				-
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,160,774,482.44	-	2,221,996,521.53	4,382,771,003.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдаа				-
Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө				-
Тайлангийн үеийн үр дүн			710,938,521.18	710,938,521.18
Өмнөх оны хуримтлагдсан элэгдэл нөхөн байгуулсан				-
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,160,774,482.44	-	2,932,935,042.71	5,093,709,525.15

Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО		
Татаас санхүүжилтийн орлого	1,049,653,050.00	1,097,415,000.00
Улсын төсвөөс		
Урсгал	1,032,350,000.00	1,097,415,000.00
Хөрөнгийн		
Орон нутгийн төсвөөс		
Бусад төсөвт байгууллагаас		
Нийгмийн даатгалын сангаас		
Бусад тусгай зориулалтын сангаас	17,303,050.00	
Тусламжийн орлого		
Бараа, үйлчилгээний орлого	3,907,053,434.32	4,179,670,392.24
Өмчийн орлого		
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	3,907,053,434.32	4,179,670,392.24
Торгууль, төлбөрийн орлого		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,956,706,484.32	5,277,085,392.24
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА		
Ажиллагчидтай холбогдсон зардал	2,486,522,911.15	2,678,421,411.55
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,245,368,983.32	2,416,999,866.27
Цалин	2,056,068,324.32	2,229,123,956.27
Цалингийн тусгай нэмэгдлүүд	39,300,659.00	22,875,910.00
Унаа хоолны хөнгөлөлт	150,000,000.00	165,000,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	241,153,927.83	261,421,545.28
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	241,153,927.83	261,421,545.28
Эрүүл мэндийн даатгалын хураамж		
Бараа үйлчилгээний урсгал зардал	1,794,681,696.07	1,504,198,758.50
Тогтмол зардал		
Гэрэл цахилгааны зардал	75,552,841.15	68,363,322.00
Түлш, халаалтын зардал	110,885,487.65	105,237,024.00
Цэвэр, бохир усны зардал	53,373,227.00	51,070,607.36
Үйл ажиллагааны зардал		
Хоол		
Эм		
Бусад бараа үйлчилгээний зардал		
Бичиг хэргийн материал	25,425,839.30	32,606,665.00
Тээвэр, шатахууны зардал	11,400,000.00	15,625,000.00
Шуудан холбооны зардал	31,575,711.41	33,372,670.21
Дотоод томилолтын зардал		4,501,650.00
Гадаад томилолтын зардал	40,337,017.00	28,734,412.00
Ном, хэвлэлийн зардал	2,835,530.00	8,773,680.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	441,072,971.00	73,816,110.00
Сургалт семинарын зардал		
Эрдэм шинжилгээний ажлын зардал	155,129,842.56	186,886,214.93
Жижиг эд хогшил худалдан авах зардал	12,721,800.00	19,245,564.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	8,303,799.00	19,603,688.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд		
Харуул, хамгаалалтын зардал	96,240,000.00	80,400,000.00
Банкны үйлчилгээний хураамж		
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	161,323,600.00	185,923,500.00
Аудитын үйлчилгээний төлбөр	13,000,000.00	3,000,000.00
Төсөл арга хэмжээ		
Урсгал засварын зардал	443,387,938.00	479,430,209.00
Биеийн тамирын уралдаан тэмцээний зардал	7,061,260.00	9,041,550.00
Гадаад зочны зардал	11,586,052.00	28,764,846.00
Тээврийн хэрэгслийн татвар	570,940.00	883,340.00
Газрын төлбөр	880,000.00	919,886.00
Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тусламж	25,359,000.00	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		



Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	61,979,000.00	59,799,370.00
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал		
Оюутны өвлийн амралтын зардал		
Бусад /Хог хаягдал устгах, цэвэрлэх зардал/	4,679,840.00	8,200,000.00
Урьд оны өр барагдуулахад		
Төвлөрүүлэх шилжүүлэг		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	4,281,204,607.22	4,182,620,170.05
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	675,501,877.10	1,094,465,222.19
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ХӨРӨНГИЙН ОРЛОГО		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Бусад хөрөнгө борлуулалтын орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	164,986,430.00	220,556,230.00
Хөрөнгийн бусад зардал		54,780,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	164,986,430.00	275,336,230.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ((VI)=(IV)-(V))	(164,986,430.00)	(275,336,230.00)
САНХҮҮЖИЛТИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Авсан зээл		
Төлсөн зээл		
САНХҮҮЖИЛТИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	510,515,447.10	819,128,992.19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,901,813,301.84	3,412,328,748.94
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,412,328,748.94	4,231,457,741.13



Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		3,412,328,748.94		
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	4,666,447,000.00	4,457,956,400.05	208,490,599.95	0.96
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	4,666,447,000.00	4,457,956,400.05	208,490,599.95	0.96
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,610,447,000.00	4,403,176,400.05	207,270,599.95	0.96
Бараа ажил үйлчилгээний зардал	4,610,447,000.00	4,403,176,400.05	207,270,599.95	0.96
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,494,400,000.00	2,416,999,866.27	77,400,133.73	0.97
Үндсэн цалин	2,285,400,000.00	2,229,123,956.27	56,276,043.73	0.98
Гэрээт ажлын цалин	44,000,000.00	22,875,910.00	21,124,090.00	0.52
Хоол, унааны хөнгөлөлт	165,000,000.00	165,000,000.00	-	1.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	274,384,000.00	261,421,545.28	12,962,454.72	0.95
Тэтгэврийн даатгал	274,384,000.00	261,421,545.28	12,962,454.72	0.95
Бичиг хэргийн материал	33,600,000.00	32,606,665.00	993,335.00	0.97
Тээвэр, шатахууны зардал	16,680,000.00	15,625,000.00	1,055,000.00	0.94
Шуудан холбооны зардал	35,918,400.00	33,372,670.21	2,545,729.79	0.93
Дотоод томилолтын зардал	5,000,000.00	4,501,650.00	498,350.00	0.90
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	111,340,000.00	84,017,910.00	27,322,090.00	0.75
Эрдэм шинжилгээний ажлын зардал	201,800,000.00	186,886,214.93	14,913,785.07	0.93
Жижиг эд хогшил худалдан авах зардал	184,240,800.00	172,602,294.00	11,638,506.00	0.94
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	24,750,000.00	19,603,688.00	5,146,312.00	0.79
Харуул, хамгаалалтын зардал	80,400,000.00	80,400,000.00	-	1.00
Аудитын үйлчилгээний хөлс	5,000,000.00	3,000,000.00	2,000,000.00	0.60
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	185,923,500.00	185,923,500.00	-	1.00
Урсгал засварын зардал	529,503,000.00	529,406,679.00	96,321.00	1.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	9,500,000.00	9,041,550.00	458,450.00	0.95
Гадаадын зочны зардал	28,800,000.00	28,764,846.00	35,154.00	1.00
Газрын төлбөр	920,000.00	919,336.00	664.00	1.00
Хог хаягдал устгах цэвэрлэх зардал	8,200,000.00	8,200,000.00	-	1.00
Тээврийн хэрэгслийн татвар	980,000.00	883,340.00	96,660.00	0.90
Тэтгэвэрт гарахад нэг удаагийн тусламж	5,565,000.00	-	5,565,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	65,545,000.00	59,799,870.00	5,745,130.00	0.91
Нэг удаагийн урамшуулал				



Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

IV. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,000,000.00	54,780,000.00	1,220,000.00	0.98
1. Дотоод хөрөнгө оруулалт	56,000,000.00	54,780,000.00	1,220,000.00	0.98
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	56,000,000.00	54,780,000.00	1,220,000.00	0.98
2. Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх	-	-	-	
V. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ			-	
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,668,447,000.00	5,277,085,392.24	(608,638,392.24)	1.13
Гадаадын төслын зээлийн санхүүжих	-	60,473,742.40	(60,473,742.40)	
Төсвөөс санхүүжих	1,097,415,000.00	1,097,415,000.00	-	1.00
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,231,457,741.13		
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		0		
Байгууллагын тоо	1	1		
Ажиллагсад бүгд	135	135	0	0
Удирдах ажилтан	10	10		
Гүйцэтгэх ажилтан	101	101		
Үйлчлэх ажилтан	24	24		
Гэрээт ажилтан				



Санхүүгийн тайлангийн аудитын хураангуй
тайлан

Огноо:2018.03.14

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2018/124/СТА-ТӨҮГ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Удирдлагын академи
--------------	-----------------------	--------------------------------------	--------------------

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Баян ташаагийн эх Аудит ХХК	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Аудитор Т.Хоролсүрэн, Ч.Чимгээ, Д.Түмэндэмбэрэл Аудиторын туслах Д.Балжирдорж Г.Хишигдулам
Аудитын нэр:	Удирдлагын академийн санхүүгийн тайлангийн аудит		

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Удирдлагын академи		1				1			
2										
3										
4										
5										
	ДҮН		1				1			



Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

Гурав. Аудитын үр дүн

2.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
A	1	2	3	4	5	6	7
1	Удирдлагын академи	2	0	2			
2							
3							
4							
5							
6							
	ДҮН	2	0	2			

2.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлж танилцуулах:


Алдаа, зөрчилтэй асуудал 1

1. Тус байгууллага нь 2015 онд өөрийн хөрөнгийн хэмжээг 302.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэгдүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг хийлгээгүй байна. Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалаар баталсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээнд зохих өөрчлөлтийг хийх зөвлөмж өглөө.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

2. Тус байгууллага нь 2014 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалтай нийцэхгүй, санхүүгийн програмын дансны кодтой зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, 18 дугаар зүйлийн 18.2-д "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн



бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулж байгууллагад ашиглагдах дансны кодыг санхүүгийн програмд нэвтрүүлэн дансны кодчилолтой ижил болгон мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

2.3 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Зөрчилгүй санал дүгнэлт

Удирдлагын академийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартд нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Гурав. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн: Албан тушаал овог нэр:
Аудитор.....Д.Түмэндэмбэрэл
Анхан шатны чанарын хяналт хийсэн: Албан тушаал овог нэр:
Аудитын тенезер.....Ч.Чимгээ
Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн: Албан тушаал овог нэр:
Захирал.....Т.Хоролсүрэн
Танилцаж зөвшөөрсөн: Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч



Удирдлагын академийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

ТАБ-СТА-В-4

АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН БҮРТЭЛ

Тайлант огноо: 2018.03.12

№	Сорил хийсэн дансны нэр	Аудитаар илэрсэн асуудал	Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө (Материаллаг бус)	Аудиторын санал (Бүртгэлийн бичигт, тооцоолол)	Тухайн байгууллагын санал (Бүртгэлийн бичигт, тооцоолол)	Уулзалтын үр дүнгийн баталгаажуулалт
1	Хөрөнгө	Тус байгууллага нь 2015 онд өөрийн хөрөнгийн хэмжээг 302,014.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэгдүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг хийлгээгүй байна. Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журмын 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт "хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.	Материаллаг бус	Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журмын 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт "хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ" гэсэн заалтыг мөрдөж ажиллах	Зөвлөмжийг хүлээн авч өөрийн хөрөнгийн нэмэгдүүлсэн хэмжээгээр өөрчлөлтийг бүртгэх ажлыг 2018 оны 04 дүгээр сард багтаан хийлгэнэ. Хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт орсноос хойш байгууллагын удирдлага солигдсон зэрэгтэй холбоотойгоор энэ өөрчлөлтийг бүртгүүлээгүй байсан.	Зөвлөмж өгөх
2	НББББББичиг	Тус байгууллага нь 2014 оноос эхлэн нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горимыг батлан мөрдөн ажиллаж байгаа боловч тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалттай нийцэхгүй санхүүгийн программын дансны кодтой зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, 18 дугаар зүйлийн 18.2-д "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.	Материаллаг бус	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйл, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь заалтад "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана", СЗЗСайдын 2000 оны 116 тоот тушаалаар батлагдсан НББББББичиг дансны үлгэрчилсэн зааврыг тус тус мөрдөж ажиллах	Хэдийгээр Удирдлагын академийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй ч байгууллагын дүрэм, буцаг зохион байгуулалт, санхүүжилтийн зарчим өөрчлөгдсөнтэй холбоотойгоор бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлага үүссэнийг хүлээн зөвшөөрч байна. Аудитын байгууллагын зөвлөмжийг хүлээн авч 2018 онд багтаан НББББББичиг бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.	Зөвлөмж өгөх

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл хөтөлсөн: Аудитор.....Л.Хоролсүрэн
 Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн:
 Дарга: [Signature] С.Зулзахар
 Нягтлан бодогч: [Signature] С.Алтансувд
 Зөвшөөрөгчийн байр шалтгааныг бичнэ.....
 У/ЖА0010 1700979

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр:
2018.03.12
"Удирдлагын академи"
АУДИТЫН ЗӨРЧИЛГИЙН НЭГТГЭЛИЙН ХҮСНЭГТ

АД	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа			Аудит хийгдсэн эцсийн үлдэгдэл			Нийт алдаа зөрчил		
		Нийт дүн	Запруулсан н	Запруулсагдаагүй	Зөвлөмж	Нийт дүн	Акт	Албан шаардлага	Зөвлөмж	Зөвлөмж
1	Тус байгууллага нь 2015 онд өөрийн хөрөнгийн хэмжээг 302,014.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэгдүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг хийлгээгүй байна. Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журмын 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт "хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.								Зөвлөмж	Зөвлөмж
2	Тус байгууллага нь 2014 оноос эхлэн нягтлан бодох бүртгэлийн бодлого ба горимыг батлан мөрдөн ажиллаж байгаа боловч тухайн баримт бичиг нь санхүүгийн тайлан бэлтгэх дансны заавар арга аргачлалтай нийцэхгүй санхүүгийн программьын дансны кодтой зөрүүтэй байна. Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг, 18 дугаар зүйлийн 18.2-д "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.								Зөвлөмж	Зөвлөмж
	Дүн									

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



УДИРДЛАГЫН АКАДЕМИ

17012 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Удирдлагын академийн гудамж, Утас/Факс: (976) 7013 3043,
E-mail: naoginfo@naog.gov.mn, http://www.naog.gov.mn

2018.01.22 № 04/13

танай _____-ны № _____-т

БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-Д

Тус Академийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлийг хүргүүлж байна.

ДЭД ЗАХИРАЛ  Б. БАЯСГАЛАН



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**